

БАТЛАВ:
“УЛААНБААТАР ЗАМ ЗАСВАР, АРЧЛАЛТЫН ГАЗАР”
ОНӨААТҮГ-ЫН ДАРГА **Б.БАЯНМОНХ**

**ХОТЫН ГОЛ БОЛОН ТУСЛАХ ГУДАМЖ ЗАМУУДЫН ТЭМДЭГЛЭГЭЭНИЙ
АЖЛЫН ГҮЙЦЭТГЭГЧИЙГ СОНГОН ШАЛГАРУУЛАХ ТЕНДЕРИЙН БАРИМТ
БИЧИГ**

Тендерийн нэр:	Хотын гол болон туслах гудамж замуудын тэмдэглэгээний ажил-1, 2, 3, 4, 5, 6, 7, 8, 9, 10, 11, 12, 13, 14, 14, 16, 17, 18, 19, 20, 21, 22, 23, 24, 25, 26, 27, 28, 29, 30, 31, 32, 33, 34
Тендер шалгаруулалтын дугаар:	УБЗЗАГ/3Т/1-34/-20200328

**Улаанбаатар хот
2020 он**

Нэг. ҮННИЙ САНАЛ АВАХ УРИЛГА

2020 оны 04 сарын 17

“Улаанбаатар зам засвар, арчлалтын газар” ОНӨААТҮГ нь сонгогдсон эрх бүхий тендерт оролцогдоос **Хотын гол болон туслах гудамж замуудын тэмдэглэгээний ажил** гүйцэтгэх тухай үнийн санал ирүүлэхийг урьж байна.

Үнийн санал ирүүлэх ажлын зураг, техникийн тодорхойлолт болон холбогдох бусад материалыг хавсаргасан болно.

Үнийн саналыг **2020 оны 04 сарын 24-ны 09 цаг 30 минутаас** өмнө **Худалдан авах ажиллагааны цахим систем** www.tender.gov.mn хаягаар өөрийн хэрэглэгчийн эрхээр нэврэн ирүүлнэ.

Үнийн саналыг нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан **2020 оны 04 сарын 24-ны өдрийн 10 цаг 00 минутанд** нээнэ.

Дотоодны давуу эрх тооцно.

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

**Улаанбаатар хот Баянзүрх дүүрэг 14 дүгээр хороолол-6 Жуковын өргөн чөлөө,
“Улаанбаатар зам засвар, арчлалтын газар” ОНӨААТҮГ-ын 2 давхарт 211 тоот,
ХАА-ын мэргэжилтэн Утас: 90792808**

Хоёр. ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА

- 1. Эрх бүхий тендерт оролцогч**
 - 1.1. Тендерт оролцогч нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйл буюу Тендер шалгаруулалтын өтөгдлийн хүснэгт /цаашид “ТШӨХ” гэх/-д заасан холбогдох шаардлагыг хангасан байна.
- 2. Тендер ирүүлэх, тендерийн нээлт**
 - 2.1. Захиалагч тендерүүдийг ТШӨХ-д заасан захиалагчийн хаягаар, ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө хүлээн авна.
 - 2.2. Тендерийг ТШӨХ-д заасан хугацаанд, ТШӨХ-д заасан газар нээлтийг хийнэ.
 - 2.3. Тендерт оролцогч тендерийн материалд Хувь хүний нууцын тухай болон Байгууллагын нууцын тухай хуулиудаар ил болгохыг хориглосон мэдээллийг тусад нь хавтаслаж ирүүлнэ. Тус хавтасны эхэнд тэдгээр мэдээллийг нууцлах үндэслэлийг бичгээр тайлбарлаж, тендерт оролцогчийн итгэмжлэгдсэн этгээд гарын үсгээр баталгаажуулна. Эрх бүхий тендерт оролцогч болохыг нотлох ТШӨХ-д заасан баримт бичиг, тендерийн баримт бичигт заасан маягтуудыг нууцлахгүй ирүүлнэ.
- 3. Тендерийн иж бүрдэл**
 - 3.1. Тендерт оролцогчдод өгсөн зааварчилгааны дагуу бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ:
 - (а) Үнийн санал;
 - (б) Үнэлэгдсэн үе шатны ажлын хуваарь;
 - (в) Чадварын мэдээлэл /санхүүгийн тайлан, туршлагын мэдээлэл, гэрээ гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар/ болон бусад баримт бичиг;
 - (г) Шаардлагатай тусгай зөвшөөрөл;
 - (д) [Бэлтгэж ирүүлэх шаардлагатай бусад материалыг жагсаана.]
- 4. Тендерийн үнэ**
 - 4.1. Тендерийн үнэд тодорхойлсон нийт ажил хамрах ба тендерт оролцогчийн үнэлж ирүүлсэн үе шатны ажлын хуваарьт үндэслэнэ.
 - 4.2. Тендерт оролцогч үнийн хөнгөлөлтийг тендерт тусган санал болгож болно.
 - 4.3. Тендерт оролцогч нь зураг болон техникийн тодорхойлолтод тодорхойлогдсон ажлыг үнэлэхдээ үе шатны ажлын хуваарьт хураангуй байдлаар өгөгдсөн бүх нэр төрөлд нэгж үнэ болон нийт үнэ санал болгоно. Тендерт оролцогч аль нэг нэр төрлийн нэгж үнэ болон нийт үнийг бөглөөгүй орхисон тохиолдолд түүнийг гүйцэтгэсний төлбөрийг захиалагч хийхгүй ба бусад нэр төрлийн үнэд багтсан гэж үзнэ.
 - 4.4. Тендерт оролцогч нь тендер хүлээн авах эцсийн хугацаанаас 14 хоногийн өмнө хүчин төгөлдөр мөрдөгдэж буй хууль тогтоомжийн дагуу энэ гэрээ болон бусад үндэслэлээр гүйцэтгэгчийн төлөх ёстой бүх татвар, хураамж, бусад төлбөрийг тендерийн нийт үнэд багтаасан байна.
- 5. Үнийн саналын**
 - 5.1. Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш 30 хоногийн хугацаанд хүчинтэй байна.

**хүчинтэй
байх хугацаа**

- 6. Алдааг залруулах**
- 6.1. Захиалагч шаардлагад нийцсэн тендерийн арифметик алдааг шалгаж дараах байдлаар залруулна:
- (а) тоо болон үсгээр илэрхийлэгдсэн дүн хоорондоо зөрсөн бол үсгээр илэрхийлэгдсэнийг зөв гэж үзнэ;
 - (б) үе шатны ажлын үнийн нийлбэр тендерийн маягтад заасан тендерийн нийт үнээс зөрвөл үе шатны ажлын үнийн нийлбэрийг үндэслэн тендерийн нийт үнийг залруулна;
 - (в) нэгж үнийг ажлын тоо хэмжээгээр үржүүлж гаргасан нэг мөр дэх нийт дүнд зөрүү гарвал нэгж үнийг давамгайлах гэж үзнэ. Гэхдээ захиалагчийн үзэж байгаагаар нэгж үнэд аравтын орны таслалыг андуурсан болох нь илэрхий байвал тухайн мөр дэх нийт дүнг зөв гэж үзэн холбогдох нэгж үнийг залруулна.
- 6.2. Захиалагчийн залруулсан тендерийн дүнг тендерт оролцогчийн зөвшөөрлөөр эцсийнх гэж үзнэ. Хэрэв тендерт оролцогч залруулсан дүнг хүлээн зөвшөөрөхгүй бол захиалагч түүний тендерээс татгалзана.
- 7. Санал болгосон үнэ, түүнийг үнэлэх**
- 7.1. Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ.
- 7.2. Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдийн үнийг харьцуулж хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно.
- 8. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл**
- 8.1. Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө утсан холбоогоор мэдэгдэж, албан бичгээр баталгаажуулна. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна.

Гурав. ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ

ТОӨЗ-НЫХОЛБОГДОХЗААЛТ	Шалгуур үзүүлэлт
ТОӨЗ 1.1	<ol style="list-style-type: none"> Сүүлийн 1 жилийн санхүүгийн тайлан /шаардлагатай бол аудитын дүгнэлтийн хамт/; Сүүлийн 1 туршлагын мэдээлэл /гэрээгээр гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар; гэрээ дүгнэсэн акт/ Шаардлагатай тусгай зөвшөөрөл хавсаргана. Зам, тээврийн сайдын 2018 оны 131 дүгээр тушаалаар батлагдсан журмын 2.8.2.7 Замын тоноглол, тэмдэг, тэмдэглэгээний ажил Тендерт оролцогч гэрээг гүйцэтгэхэд зайлшгүй шаардлагатай үндсэн тоног төхөөрөмж, машин механизмуудын жагсаалтыг ирүүлнэ. Инженер техникийн ажилчдын жагсаалтыг ирүүлнэ Тухайн ажлыг гүйцэтгэх график, төлөвлөгөө, хуваарь Тухайн ажлын төсөв Ажлын тоо хэмжээ
ТОӨЗ 1.2	Санхүүжилтийн эх үүсвэр: Нийслэлийн замын сангийн хөрөнгөөр 2020-2021 онд
ТОӨЗ 2.1	<p>Тендер хүлээн авах хаяг, эцсийн хугацаа нь: Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг 14 дүгээр хороолол-б Жуковын өргөн чөлөө. “Улаанбаатар зам засвар, арчлалтын газар” ОНӨААТҮГ Огноо: 2020 оны 04 дугаар сарын 24-ны өдөр Цаг: 09 цаг 30 минут</p>
ТОӨЗ 2.1	<p>Тендерийн нээлт хийх газар, хугацаа нь: Уг тендер нь цахим тендер шалгаруулалтын журмаар зохион байгуулагдаж байгаа тул тендерт оролцогч нь цахим худалдан авах ажиллагааны системе www.tender.gov.mn -д өөрийн аж ахуйн нэгжийн хувийн нууцлалын кодоор нэвтрэн орж тендерийн материалыа цахим хэлбэрээр ирүүлнэ. Огноо: 2020 оны 04 дугаар сарын 24-ны өдөр Цаг: 10 цаг 00 минут</p>
ТОӨЗ 2.3	<p>Долдугаар бүлгийн маягтуудаас гадна эрх бүхий тендерт оролцогч болохыг нотлох дараах баримт бичиг, материалыг өөрийн тендертээ нууцлахгүй ирүүлнэ. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> Улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар /нотариатаар гэрчлүүлсэн байх/ Тендерт оролцогчийг төлөөлж гарын үсэг зурсан этгээдийн итгэмжлэл Шүүхийн тодорхойлолт Бараан шинжилгээний бичиг /нотариатаар гэрчлүүлсэн байх/
ТОӨЗ 5.3 (а)	Борлуулалтын орлогын хэмжээ: Шаардахгүй
ТОӨЗ 5.3 (б)	Ижил төстэй ажлыг доод тал нь нэг удаа гүйцэтгэгдсэн байвал зохих жилийн тоо: Шаардахгүй

Дөрөв. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

БАТЛАВ.
НИЙСЛЭЛИЙН АВТО ЗАМЫН ХӨГЖЛИЙН
ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭЧ

Б.ИНДРА

НИЙСЛЭЛИЙН ГУДАМЖ ЗАМД ХӨДӨЛГӨӨН ЗОХИЦУУЛАХ ХЭВТЭЭ БОЛСОС
ТЭМДЭГЛЭЛ ХИЙХ АЖЛЫН ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

1. Ерөнхий зүйл	Улаанбаатар хотын замын хөдөлгөөний зохион байгуулалт, хөдөлгөөний горим, нехцел байдлыг хөдөлгөөнд оролцогчдод мэдээлэх зорилгоор зорих хэсгийн гадаргуу буюу түүний хашлага, замын байгууламж, тэдгээрийн элементүүд дээр тусгайлан шугам, сум, бичлэг, зураас зэрэг тэмдэглэл хийх ажлуудаас бурдэнэ. Нийт 98-н гудамж зам, Сургууль, цэцэрлэг орчмын явган хүний гарц, хурд сааруулагч, Уулзварын шар дөрвөлжин тэмдэглэлийн ажил хийгдэнэ.
2. Барилгын талбайн үзүүлэлт	Авто замын зорих хэсэг дээрх хэвтээ тэмдэглэл нь ихэнх авто замуудад будгэрч, зарим хэсэгтээ арилж замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангуулахад сергеер налеөлж байгаа нь хэвтээ тэмдэглэлийг зайлшгүй сэргээх, шинээр хийх шаардлагатайг харуулж байна. Эдгээр 98-н гудамж зам, Сургууль, цэцэрлэг орчмын явган хүний гарц, хурд сааруулагч, Уулзварын шар дөрвөлжин тэмдэглэл хийгдэх гудамж замуудын зорих хэсэг нь асфальтбетон болон цементбетон хүчилттай болно.
3. Ажлын цар хурээ	<p>Авто замын тэмдэглэл техникийн еренхий шаардлага MNS-4759:2014", "Авто замын тэмдэглэл, гэрлэн дохио, хаалт, хашилт чиглүүлэх хэрэгслүүдийг хэрэглэх дүрээм" MNS-4596:2014 стандартуудыг үндэслэн инженерийн зааврын дагуу хийгдэнэ.</p> <p>Хэвтээ тэмдэглэлийн өргөн дараах хэмжээтэй байна.</p> <ul style="list-style-type: none">- Шугаман тэмдэглэлийн өргөний хэмжээ ба хос шугаман тэмдэглэлийн шугамуудын зэрэгцээ хоорондын зайн хэмжээг MNS 4759 : 2014 зааснаас 10 мм, тасархай зураасны уртын хэмжээ болон хоорондын зайн 50 мм-ээс илүү зөрүүтэй хийгүй. Бусад тэмдэглэлийн шугаман хэмжээний алдаа 5 %-аас ихгүй байвал зохино. <p>Термопластик техникийн тодорхойлолт</p> <ul style="list-style-type: none">- Үйлдвэрлэснээс хойш 3-н сараас ихгүй хугацаатай термопластик хэрэглэнэ.- Цацуулагчийг зориулалтын тоног төхөөрөмжжөөр даралтаар жигд цацах.- Ажлын талбай дээр зориулалтын термометртэй байх.- Термопластикийн дэвсэх үеийн температур 180-200° С байна.- Тэмдэглэлийн чигийн хулцэх алдаа 5мм- Термопластикийн дэвсэх үеийн зузаан 3-4мм байна.- Тэмдэглэл хийх үед гааарын температур 8°С-аас багагүй байх- Тэнхлэг, тасархай 4 мм-ээс дээш зузаантай байх- Хөөвөний тэмдэглэл 3 мм-ээс дээш зузаантай байх- Үйлдвэрийн уутан дээр үйлдвэрлэгдсэн хугацааг зааж өгсөн байх- Тэмдэглэгээний материал нь 3мм-4мм зузаантай үед 1м.кв талбайд 7,5-8кг байна.- Тээврийн хэрэгслийн хөдөлгөөний эсрэг ургалыг тусгаарлах, замын аюул бүхий хэсэгт энгээний хилийг тэмдэглэх, чиглэлийн тээврийн хэрэгсэл буюу унадаг дугуйн хөдөлгөөнд зориулсан эгнээг бусад энгээнээс тусгаарлах, зорих хэсгийн орохын хориглосон хэсгийн хилийг тэмдэглэх, тээврийн хэрэгслийн зогсоолын хилийг тэмдэглэхд тус бүр 0,15 м өргентэй- Зорих хэсгийн захыг 0,1-0,20м өргентэй- Тээврийн хэрэгслийн түр зогсохыг хориглосон газрыг 0,10м өргентэй

- Тээврийн хэрэгслийн хөдөлгөөний эсрэг урсгалыг тусгаарлах болон эgnээний хилийг 0.15м
- Тээврийн хэрэгслийн хөдөлгөөний дагуу буюу эсрэг урсгалыг тусгаарласан 1.1, 1.10 тэмдэглэлд ойртож байгааг анхааруулах тэмдэглэл 0.15м
- Уулзвар дээрхи хедалгөөний эgnээг тэмдэглэх 0.15 м.
- Хурд авах буюу хурд хасах эgnээг зорчих хэсийн үндсэн эgnээнээс тусгаарласан хилийг тэмдэглэх-0.20м
- Тээврийн хэрэгслэл удаан зогсохыг хориглосон газрыг тэмдэглэх-0.10м
- ЗОГС шугам 0.40м
- "Явган хүний гарц" тэмдэглэлийн өргөн 0.40м, хоорондын зайд 0.60м.
- Хурд сааруулагийг тэмдэглэлийг хийхдээ /шар 0.45-0.50м/, /цагаан 0.45-0.50м/ налуу ёнцөг 60° MNS 4759:2014 стандартын 1.23 заагдсаны дагуу хийж гүйцэтгэнэ.

Термопластикийн өнгөний коэффициент

Өнгө	Үрэлтийн коэффициент	Өнгөний координат		Гэрэл тодроцын коэффициент $B_v, \%$	Өдрийн цагт узэгдэх байдал $Q_d, \text{мкд}\cdot\text{лк}^{-1}\cdot\text{м}^{-2}$	Гэрэл ойлголтын коэффициент $R_L, \text{мкд}\cdot\text{лк}^{-1}\cdot\text{м}^{-2}$
		x	y			
Шар	0,34	0,48	0,422	44 (29)	162	190
Цагаан	0,31	0,31	0,345	80 (48)	220	270

Үрголжилсан шугаман тэмдэглэлийг аль болох залгаас хоорондын завсаргүйгээр хийвэл зохих бөгөөд технологийн хувьд боломжгүй тохиолдолд завсрлын зайд нь 50 мм-ээс илүүгүй, вэр хоорондоо 20 м-ээс ойргүй байвал зохино.

- Хэвтээ тэмдэглэлийн барьцалтын коэффициент нь ашиглалтын аль ч үед тухайн зорчих хэсгийнхээ гадаргуугийн барьцалтын коэффициентын утгаас 25 %-аас илүү ялгаатай байх ёсцүй.
- Хуучирсан тэмдэглэлийг сэргээн шинэчлэх тохиолдолд хуучин ул мэр нь шинэ тэмдэглэлийн захаас тасархай зураасны хувьд уртын дагуу 50 мм-ээс, бусад хэмжээний хувьд 10 мм-ээс илүү цуухайгаагүй байвал зохино.
- Тэмдэглэлийн хэмжилт хийх хэсгийн гадаргуупийн талбай (C) нь өө сэвгүй тэгш, цэвэр байх бөгөөд түүний замын дагуух уртын хэмжээ нь 220 мм-ээс, өргөн нь 50 мм-ээс барагүй байвал зохино.
- Хэмжилтийг тухайн тэмдэглэлийн гадаргуу хуртэл 30 м-ийн зайнас хийнз. Энэ тохиолдолд ажиглах ёнцөг $\alpha = 1.05^\circ$, гэрэлтүүлэх ёнцөг $\beta = 1.24^\circ$ байна.

Гэрэл ойлготч /сахар/

- Гэрэл ойлготч /сахар/-ыг зориулалтын машинаар үлзэлгэн шигтгэж цацна.
- Гэрэл ойлготч /сахар/ тэмдэглэлийн нийт талбайн 50%-с дээш хувийг эзэлсэн байна.
- Тэмдэглэлийн зузаанаас шалтгаалан гэрэл ойлготч /сахар/-ын ширхэглэлийг сонгож авна.
- Гэрэл ойлгог /сахар/-ын зузаан 0.5мм-1мм байж болно.
- Гэрэл ойлготч сахар нь өөрийн нийт хэмжээний $\frac{1}{4}$ буюу 75% нь термопластикт шигдсэн байх ёстай.
- Гэрэл ойлготч /сахар/ 1m^2 талбайд 200-300г хэрэглэнэ.

№	Үзүүлэлт	Техникийн шаардлага
1	Гадна шинж чанар	Тунгалаг, хоорондоо наалддаггүй, Зөв хэлбэртэй,
2	Гэрэл ойлготчид агуулагдах агаарын хэмжээ	5 хувиас ихгүй

		3 Зөв бус хэлбэр	20 хувиас ихгүй
		4 Үндсэн фракц	50 хувиас их байх ёстой
		5 Хамгийн бага хэмжээ	100 мкм
		6 Хамгийн их хэмжээ	600 мкм
		7 Шилний хугаралтын коэффициент	1,5-1,65
		8 Нийт	2,4-2,6 г/см ³
		9 Гэрэл ойлгогчийн диаметр	500 мкм /50 хувиас дээш хувь/
4.Ажлын хил хязгаар		Нийслэлийн нийт 98-н гудамж зам, Сургууль, цэцэрлэг орчмын явган хүний гарц хурд сааруулагч, Уулзварын шар дөрвөлжин тэмдэглэл, замуудад хийгдх тэмдэглэгээний ажлын хил хязгаар, эхлэл төгсгөл, ажлын тоо хэмжээг хавсралтаар үзүүлэв.	
5.Барилгын ажлын зохион байгуулалт		<p>Хэвтээ тэмдэглэлийн хэрэглэх материалыг итгэмжлэгдсэн лабораторийн дүгнэлтийг үндэслэн чанарын шаардлага хангасан тохиолдолд ажлыг эхлүүлнэ. Тэмдэглэл тавих байршилыг урьдчилан тогтооходо замын тэмдэглэлтий ижил ёнгийн будгаар 10 мм голчтой цэгүүд тавьж тэмдэглэнэ. Хэвтээ босоо тэмдэглэлийн гадаргуугийн тодроц буюу гэрэл ойлгох коэффициент нь тухайн замын үзүүлэлт нөхцөлөөс хамааран ажлын цар хүрээнд заагдсан Термопластикийн ёнгений коэффициент болон MNS4759:2014 стандартын 3 дугаар хүснэгтэд заагдсан утгаас багагүй байна.</p> <p>Агаарын харьцангуй чийгшил 80%-аас их, Салхины хурд тэмдэглэлийн ажилд сергеөр нөлөөлне гэж хяналтын инженер үзвэл тэмдэглэлийн ажлыг зогсоноо. Хуучин хэвтээ тэмдэглэл дээр будахад зузаан нь 6 мм-ээс хэтэрсэн тохиолдолд хусах, арилгах арга хэмжээг авч техник стандарт, инженерийн зааварчилгааны дагуу шинээр хийж гүйцэтгэнэ.</p> <p>Асфальтбетон гадаргуу дээр замын тэмдэглэлийг битумын дэгдэмхий бодис уурших хангалттай хугацаа ёнгөрсний дараа тавина.</p> <p>Тэмдэглэл тавих гадаргууг хийн даралтаар шаардлагатай хэмжээнд хүртэл хатааж цэврлэнэ.</p> <p>Зориулалтын цавуугаар тэмдэглэл хийх талбайд жигд түрхэнэ. /20-30 минут/ Тэмдэглэл хийгдсэн талбайг хаттал замын хөдөлгөөн зориухоос хамгаална. Гүйцэтгэг шаардлагатай хаалт хамгаалалт, тэмдэг, түмбэ, хамгаалалтын хэрэгслийдийг байрлуулах ба бусад шаардлагатай арга хэмжээг авч хөдөлгөөн зохион байгуулалт, хөдөлмөр хамгаалалт аюулгүй байдал ажиллагааг нарийн баримтлан ажиллана. НАЗХГ -ын даргын 2016 оны А42 дугаар тушаалаар баталсан "Авто замын барилга, засварын хяналтын инженерийн гарын авлагыг баримтлан ажлын үе шат бүрт нэг цэгээс фото зураг авч инженерээр баталгаажуулна.</p> <p>Тэмдэглэлийн ажил дууссан өдрөөс хойш 21 хоногийн дотор гүйцэтгэлийн баримт бичгийг захиалагчид цаасаар болон цахим хэлбэрээр хүлээлгэн өгнө. Үе шатны ажил бүрт хөдөлгөөн зохион байгуулалтын зураглал хийж, зөвшөөрлийн хуудсаар баталгаажуулж хяналтын инженерийн зааварчилгааны дагуу ажиллана. Өдөр бүр ажлын явцыг цахим/ Viber, messenger/ хэлбэрээр болон фото зурагар хяналтын инженерт мэдээлна.</p>	

Тендерт оролцогч гэрээг гүйцэтгэхэд зайлшгүй шаардлагатай инженер техникийн ажилтан

№	Албан тушаал	Хүний тоо	Ажлын туршлага/жил/
1	Авто замын хөдөлгөөн зохион байгуулалтын инженер	2	2-оос дээш жил ажилласан байх
2	Авто замын инженер	1	2-оос дээш жил ажилласан байх
3	Хөдөлмөр хамгаалалт аюулгүй байдлын инженер	3	1-эс дээш жил ажилласан байх

Тендерт оролцогч гэрээг гүйцэтгэхэд зайлшгүй шаардлагатай тоног төхөөрөмж

№	Тоног төхөөрөмж нэр	х/н	Тоо	Хүчин чадал	Тайлбар
1	Пластик материал халаагч	ком	7	2 тн-оос дээш багтаамжтай	Цагаан, шар өнгийн тэмдэглэл хийдэг байх
2	Авто замын гадаргууг хийн даралтаар цэвэрлэгч	ком	7		Минутад 10 м ² цэвэрлэх чадамжтай
3	Наалдуулагч бодис түрхэгч	ш	7		Минутад 10м ² дэвсэх чадамжтай
4	Замын тэмдэглэл хийх тоноглол / гэрэл ойлгогчийг жигд даралтаар цацагчтай/	ком	7		Жигд хэмжээгээр дэвсэх чадвартай, гадаргуу дээр тэгш ирмэгтэй, урсалт болон үсэргээгүй тэмдэглэл тавих чадвартай.
5	Арилгагч төхөөрөмж / усан даралттай болон булт/	ком	7		Хуучин хэвтээ тэмдэглэл дээр будахад 6 мм-ээс хэтэрсэн тохиолдолд хусаж, арилгана.
6	Температур хэмжигч термометр	ш	7		Пластик материал халаагчийн температур шалгах, Стандартчилал хэмжил зүйн газраар баталгаажуулсан байх шаардлагатай.

Хянасан:

Нийслэлийн Авто замын хөгжлийн газрын Орлогч даргын үүргийг түр орлон гүйцэтгэх

Д. Төрбилэг

НАЗХГ-ын Засвар ашиглалт хяналтын хэлтсийн дарга

Б. Цэрэнсодном

Боловсруулсан:

НАЗХГ-ын Засвар ашиглалт хяналтын хэлтсийн ахлах мэргэжилтэн

Э. Мөнх-Од

НАЗХГ-ын Засвар ашиглалт хяналтын хэлтсийн Хөдөлгөөн зохион байгуулалтын мэргэжилтэн

Б. Ширэндэв

Тав. ЗУРАГ

Зургийн санамж

Энд зургуудыг жагсааж бичнэ. Зураг, түүний дотор ажлын талбайн зургийг энэ бүлэгт, эсхүл тусад нь хавтсанд хийж хавсаргана.

Зургаа. ҮЕ ШАТНЫ АЖЛЫН ХУВААРЬ

1. Хуучин тэмдэглэгээг хусаж, цэвэрлэх
2. Тэмдэглэгээ хийх тус тус үе шатны ажлын хуваарь гаргах

Долоо. ЖИШИГ МАЯГТ

ҮНИЙН САНАЛЫН МАЯГТ

[огноо]

(Захиалагч байгууллагын нэр)-ын дарга _____ танаа

- Бид, [тендерт оролцогчийн нэр], [гэрээний нэр ба дугаар]-ыг [тендерийн үнийг тоогоор болон үсгээр] төгрөгөөр тендерийн баримт бичгийн дагуу гүйцэтгэхээр санал болгож байна.
- Тендер нь тендерийн баримт бичигт заасны дагуу тендер хүлээн авах эцсийн хугацаанаас хойш **30** хоногийн хугацаанд хүчинтэй байх ба та энэ хугацаа дуусахаас өмнө түүнийг сонгох боломжтой.
- Гэрээг албан ёсоор байгуулах хүртэл энэхүү тендер болон түүнийг шалгарсан тохиолдолд гэрээ байгуулах эрх олгох мэдэгдэл нь бидний хооронд хийгдсэн хэлцэл болно.
- Бид гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна гэдгийг үүгээр батламжилж байна.
- Бид тендерийг холбогдох журмын дагуу бусад тендерт оролцогчдод ил болгохыг үүгээр зөвшөөрч байна. Захиалагч бидний ирүүлсэн тендерийг нууцлах аливаа үүргээс бүрэн чөлөөлөгднө.

Тендерт оролцогчийн нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг:

Найм. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

- | | |
|---|---|
| 1. Гүйцэтгэгч ажил гүйцэтгэх | 1.1. Гүйцэтгэгч гэрээний тусгай нөхцөлд заасан ажлыг техникийн тодорхойлолт болон зургийн дагуу хийж гүйцэтгэнэ. |
| 2. Төслийн менежерийн шийдвэр | 2.1. Гэрээнд тусгайллан заагаагүй бол гэрээтэй холбогдсон аливаа асуудлыг захиалагчийг төлөөлөн төслийн менежер шийдвэрлэнэ. |
| 3. Ажил дуусгахаар төлөвлөсөн өдөр ажил дууссан байх | 3.1. Гүйцэтгэгч ажлыг гэрээний тусгай нөхцөлд заасан өдөр эхлүүлж, өөрийн гаргасан ажлын хөтөлбөр болон төслийн менежерийн баталсан тодотгосон ажлын хөтөлбөрийн дагуу хийж гүйцэтгэн, ажил дуусгахаар төлөвлөсөн өдөр дуусгана. |
| 4. Аюулгүй байдал | 4.1. Гүйцэтгэгч ажлын талбай дээрх бүх үйл ажиллагааны аюулгүй ажиллагааг хангаж ажиллана.
4.2. Барьж байгаа барилга, байгууламжаа байгалийн болзошгүй гамшиг, гэнэтийн аюулаас хамгаалах бүх талын арга хэмжээг авч, өөрийн нь ажилтай холбогдуулж барилгын болон байгаль орчин, эрүүл ахуй, гал түймрийн хяналтын албанаас гаргасан хууль ёсны шаардлага, дүгнэлтийг хүлээн авч биелүүлнэ. |
| 5. Зааварчилгаа | 5.1. Төслийн менежерийн гаргах аливаа зааварчилгаа нь Монгол улсын хууль, тогтоомжид нийцсэн байх бөгөөд түүнийг гүйцэтгэгч биелүүлэх үүрэгтэй |
| 6. Маргааныг шийдвэрлэх | 6.1. Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гарана. |
| Б. ХУГАЦААНЫ БОЛОН ЧАНАРЫН ХЯНАЛТ | |
| 7. Ажлын хөтөлбөр | 7.1. Гүйцэтгэгч нь ажил гүйцэтгэхэд шаардлагатай бүх үйл ажиллагааны ерөнхий аргачлал, зохион байгуулалт, дэс дараалал, ажил гүйцэтгэх хугацаа болон бусад шаардлагатай мэдээллийг тусгасан ажлын хөтөлбөрийг боловсруулж, гэрээний тусгай нөхцөлд заасан хугацаанд төслийн менежерт хүргүүлж батлуулна.
7.2. Ажлын хөтөлбөрийг төслийн менежер батлах нь гүйцэтгэгчийн үүрэг хариуцлагыг хөндөхгүй. Гүйцэтгэгч нь ажлын хөтөлбөрийг хянан засварлаад төслийн менежерт хэдийд ч дахин хүргүүлж болно. Хянан засварласан ажлын хөтөлбөрт өөрчлөлтийг тусгана. |
| 8. Зөрчил, гологдол илрүүлэх | 8.1. Төслийн менежер гүйцэтгэгчийн ажлыг шалгаж, илэрсэн зөрчил, гологдлын талаар түүнд мэдэгдэнэ. Энэхүү шалгалт нь гүйцэтгэгчийн үүрэг хариуцлагыг хөндөхгүй. Төслийн менежер зөрчил, гологдол байж болзошгүй гэж үзсэн аливаа ажилд зөрчил, гологдол хайх, уг ажлын далд хэсгийг нээж шалгалт, туршилт явуулах талаар зааварчилгааг гүйцэтгэгчид өгөх эрхтэй. |
| 9. Зөрчил, гологдол арилгах | 9.1. Төслийн менежер гэрээний тусгай нөхцөлд заасан чанарын баталгаат хугацаа ¹ дуусахаас өмнө зөрчил, гологдол арилгах тухай мэдэгдлийг гүйцэтгэгчид өгнө. Чанарын баталгаат хугацааг зөрчил, гологдлыг арилгаж дуусах хүртэл сунгана. |

¹ Чанарын баталгаат хугацааг тогтоохдоо Иргэний хууль болон Барилгын тухай хуулийг баримтална.

- | | |
|---|--|
| 10. Зөрчил, гологдол арилгахгүй байх | <p>9.2. Зөрчил, гологдол арилгах тухай мэдэгдэл өгсөн тухай бүр гүйцэтгэгч уг зөрчил, гологдлыг төслийн менежерийн мэдэгдэлд заасан хугацаанд багтааж өөрийн зардлаар арилгана.</p> <p>10.1. Хэрэв гүйцэтгэгч зөрчил, гологдлыг төслийн менежерийн мэдэгдэлд заасан хугацаанд багтааж арилгаагүй бол төслийн менежер зөрчил, гологдол арилгахад шаардагдах зардлыг тооцож гүйцэтгэгчээс гаргуулна.</p> |
|---|--|

В. ЗАРДЛЫН ХЯНАЛТ

- | | |
|---|--|
| 11. Үе шатны ажлын хуваарь | <p>11.1. Төслийн менежерийн шаардсаны дагуу гүйцэтгэгч үе шатны ажлын тодотгосон хуваарийг 14 хоногийн дотор бэлтгэж ирүүлнэ. Үе шатны ажлын хуваарь тусгагдсан үйл ажиллагаа нь ажлын хөтөлбөрт тусгагдсан үйл ажиллагаатай нийцсэн байна.</p> <p>11.2. Ажлын талбай дахь материалын төлбөрийг тусад нь хийх бол гүйцэтгэгч ажлын талбайд нийлүүлсэн материалын тооцоог үе шатны ажлын хуваариас тусад нь гаргаж ирүүлнэ.</p> |
| 12. Үе шатны ажлын хуваарийг өөрчлөх | <p>12.1. Гүйцэтгэгчийн шийдвэрээр ажлын арга барил, эсхүл ажлын хөтөлбөрт гарсан өөрчлөлтийг тусгах зорилгоор гүйцэтгэгч үе шатны ажлын хуваарь нэмэлт өөрчлөлт хийнэ. Өөрчлөлт хийхдээ үе шатны ажлын хуваарь дахь үнийг өөрчлөхгүй.</p> |
| 13. Алданги | <p>13.1. Гүйцэтгэгч нь ажил дуусгахаар төлөвлөсөн өдрөөс хугацаа хоцорсон хоног тутамд гэрээний тусгай нөхцөлд заасан хувь хэмжээгээр алданги² төлнө. Алдангийн нийт дүн гэрээний тусгай нөхцөлд заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй. Захиалагч нь алдангийг гүйцэтгэгчид төлөх төлбөрөөс сүүтган авч болно. Алданги төлсөн нь гүйцэтгэгчийн хүлээсэн үүрэг хариуцлагыг хөндөхгүй.</p> |

Г. ГЭРЭЭГ ДУУСГАХ

- | | |
|--------------------------|--|
| 14. Ажил дуусгах | <p>14.1. Гүйцэтгэгч нь ажил дууссан тухай мэдэгдэл гаргах хүсэлтийг төслийн менежерт тавих бөгөөд төслийн менежер ажил дууссан гэж үзвэл уг мэдэгдлийг гаргана. Гүйцэтгэгч гадна тохижилтын ажлыг бүрэн дуусгаж, ажлын явцад гудамж, зам, талбай сэтэлж, мод, цэцэрлэгжүүлэлтийг түр зайлцуулсан бол эдгээрийг бүрэн хэмжээгээр сэргээсэн байна.</p> |
| 15. Хүлээж авах | <p>15.1. Төслийн менежер ажил дууссан тухай мэдэгдэл гаргаснаас хойш захиалагч долоо хоногийн дотор ажлын талбай болон ажлыг хүлээж авна.</p> |
| 16. Эцсийн тооцоо | <p>16.1. Гүйцэтгэгч гэрээний дагуу төлөгдөх ёстой гэж үзэж буй нийт төлбөрийн нарийвчилсан тооцоог гаргаж, чанарын баталгаат хугацаа дуусахаас өмнө төслийн менежерт хүргүүлнэ.</p> <p>Төслийн менежер зөрчил, гологдол арилгасан тухай мэдэгдэл гаргаж, хэрэв гүйцэтгэгчийн ирүүлсэн тооцоо бүрэн гүйцэд, үнэн зөв бол уг тооцоог хүлээн авснаас хойш 28 хоногийн дотор гүйцэтгэгчид төлөх эцсийн төлбөрийг тодорхойлно.</p> <p>Хэрэв тооцоо буруу байвал шаардлагатай залруулга, нэмэлт өөрчлөлтийн талаарх тайлбарыг 28 хоногийн дотор гаргаж гүйцэтгэгчид хүргүүлнэ. Хэрэв засвар хийж дахин ирүүлсэн эцсийн тооцоо нь шаардлага хангагүй бол төслийн менежер гүйцэтгэгчид төлөх дүнг шийдвэрлэж төлбөрийн мэдэгдэл гаргана.</p> |

² Алдангийг ихэвчлэн хоногт 0.05-0.10 хувиар тогтоох бөгөөд нийт дүн нь гэрээний үнийн 5-10%-иас хэтрэх ёсгүй.

- 17. Ашиглалт, засвар, үйлчилгээний гарын авлага**
- 17.1. Гүйцэтгэгч ажлын гүйцэтгэлийн зураг, далдлагдсан ажил, инженерийн шугам сүлжээ, технологийн тоног төхөөрөмжийг туршиж тохируулсан акт болон захиалагч шаардсан бол ашиглалт, засвар үйлчилгээний гарын авлагыг гэрээний тусгай нөхцөлд заасан хугацаанд хүлээлгэн өгнө.
- 17.2. Хэрэв гүйцэтгэгч 22.1-д заасан материалыг гэрээний тусгай нөхцөлд заасан хугацаанд ирүүлээгүй, эсхүл шаардлага хангаагүй улмаас тэдгээрийг төслийн менежер батлаагүй бол гүйцэтгэгчид төлөх ёстой төлбөрөөс төслийн менежер гэрээний тусгай нөхцөлд заасан үнийн дунг суутгана.
- 18. Гэрээг цуцлах**
- 18.1. Захиалагч, эсхүл гүйцэтгэгч нөгөө тал нь гэрээг ноцтой зөрчсөн гэж үзвэл гэрээг цуцлах эрхтэй.
- 18.2. Дор дурдсан нөхцөлүүдийг гэрээний ноцтой зөрчил гэж үзэх бөгөөд эдгээрээр хязгаарлагдахгүй:
- (а) ажлын хөтөлбөрт ажил зогсоох тухай заагаагүй, түүнчлэн ажил зогсоох тухай шийдвэрийг төслийн менежер батлаагүй байхад гүйцэтгэгч ажлыг 14 буюу түүнээс дээш хоногийн хугацаагаар зогсоосон;
- (б) төслийн менежер ажлын явцыг зогсоох зааварчилгааг гүйцэтгэгчид өгсөн бөгөөд уг шийдвэрээ 14 хоногийн дотор цуцлаагүй;
- (в) захиалагч, эсхүл гүйцэтгэгч дампуурсан, эсхүл өөрчлөн байгуулагдах, нэгдэхээс бусад зорилгоор татан буугдсан;
- (г) тодорхой зөрчил, гологдлыг арилгаж чадаагүй нь гэрээний ноцтой зөрчил болохыг төслийн менежер гүйцэтгэгчид мэдэгдсэн бөгөөд гүйцэтгэгч нь уг зөрчил, гологдлыг заасан хугацаанд нь багтаан арилгаж чадаагүй;
- (д) гүйцэтгэгч ажлын гүйцэтгэлийг гэрээний тусгай нөхцөлд заасан алдангийн дээд хэмжээ төлөх хугацаагаар хоцроосон.
- 18.3. Гэрээг цуцалсан тохиолдолд гүйцэтгэгч ажлыг даруй зогсоож, ажлын талбайн бүрэн бүтэн, аюулгүй байдлыг хангаж, түүнийг аль болох түргэн хугацаанд чөлөөлнө.
- 19. Гэрээг цуцалсан үед хийх төлбөр**
- 19.1. Гүйцэтгэгч гэрээг ноцтой зөрчсөний улмаас гэрээ цуцлагдсан бол төслийн менежер гүйцэтгэсэн ажлын болон захиалсан материалын үнэлгээг нотолсон мэдэгдэл гаргана. Ингэхдээ мэдэгдэл олгосон өдөр хүртэл дуусаагүй ажлын гэрээний тусгай нөхцөлд заасан хэмжээг дээрх үнэлгээнээс хасна. Нэмэлт алданги гүйцэтгэгчид ногдуулахгүй.
- 19.2. Гэрээг захиалагчийн шаардлагаар, эсхүл гэрээг захиалагч ноцтой зөрчсөний улмаас цуцалсан бол гүйцэтгэсэн ажлын болон захиалсан материалын үнэлгээ, тоног төхөөрөмжийг ажлын талбайгаас гаргах бодит зардал, ажлын зорилгоор хөлслөн ажиллуулсан гүйцэтгэгчийн ажилтнуудыг буцаахтай холбогдсон зардал, түүнчлэн ажлыг хадгалах, хамгаалахтай холбогдсон зардал зэрэг гүйцэтгэгчийн зардлыг төслийн менежер хянаж мэдэгдэл гаргана.

20. Гүйцэтгэлээс 20.1. Гэнэтийн болон давагдашгүй хүчний нөхцөл байдлын улмаас гэрээг гүйцэтгэх боломжгүй болсон бол төслийн менежер үүнийг гэрчилнэ. Гүйцэтгэгч нь энэхүү мэдэгдлийг хүлээн авсны дараа ажлын талбайн бүрэн бүтэн байдлыг хангаж, ажлыг аль болох богино хугацаанд зогсоно. Захиалагч уг мэдэгдэл гарахаас өмнө хийгдсэн ажил болон түүний дараа захиалгаар гүйцэтгэсэн ажлын хөлсийг гүйцэтгэгчид төлнө.

Ес. ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ³

ГЕН 2.1	Хотын гол болон туслах гудамж замуудын тэмдэглэгээний ажил-1, 2, 3, 4, 5, 6, 7, 8, 9, 10, 11, 12, 13, 14, 14, 16, 17, 18, 19, 20, 21, 22, 23, 24, 25, 26, 27, 28, 29, 30, 31, 32, 33, 34 УБЗЗАГ/ЗТ/1-34/-20200328
ГЕН 2.1	Ажил нь [төвч тодорхойлолт, түүний дотор төслийн хүрээнд бусад гэрээтэй холбогдох байдал]-аас бүрдэнэ. Ажлын талбай нь [байршил]-д байрших ба зураг №...-д зааснаар тодорхойлогдсон болно.
ГЕН 3.1	Төслийн менежер нь [томилогдсон этгээдийн нэр, хаяг]
ГЕН 4.1	Ажил эхлэх өдөр Гэрээ байгуулсан өдөрөөс эхэлнэ. Ажил дуусгахаар төлөвлөсөн өдөр Ажлын график, үе шатны хуваарийн дагуу 2020 оны 08 дугаар сарын 30-наас өмнө дууссан байна.
ГЕН 7.1	Гүйцэтгэгч гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдлийг хүлээн авснаас хойш [3] хоногийн дотор тодотгосон ажлын хөтөлбөрийг гаргана.
ГЕН 9.1	Чанарын баталгаат хугацаа 365 хоног байна. Ажил хүлээлгэж өгсөнөөс хойш
ГЕН 13.1	Алданги ногдуулах хэмжээ хоногт гэрээний үнийн [0,01 хувь] байна. ⁴ Нийт ажилд ногдуулах алдангийн дээд хэмжээ нь гэрээний үнийн [10 хувь] байна.
ГЕН 17.1	Ашиглалт, засвар үйлчилгээний гарын авлагыг [5] -ны дотор гаргаж өгнө. Гүйцэтгэлийн зургийг ажил дууссанаас хойш ажлын 5 хоногийн дотор гаргаж өгнө. Гүйцэтгэлийн зургийг, эсхүл ашиглалт, засвар үйлчилгээний гарын авлагыг хугацаанд нь гаргаж өгөөгүй тохиолдолд суутгах төлбөрийн хэмжээ [500,000] байна.
ГЕН 19.1	Ажил дуусгахад захиалагчаас гарах нэмэлт зардлыг дуусаагүй ажлын [0 хувь]-иар тооцно.

³ Захиалагч тендерийн баримт бичгийг тараахаас өмнө гэрээний тусгай нөхцөлийг бүрэн бөглөсөн байна.
Захиалагчийн гаргах хуваарь, тайланг гэрээний тусгай нөхцөлд хавсаргана.

⁴ Ажлыг хэсэг хэсгээр дуусгах болон хэсэг бүрт алданги хэрэглэх бол энд тусгана.

ГЭРЭЭНИЙ МАЯГТ

ЗАХИАЛАГЧ

ГҮЙЦЭТГЭГЧ

(Тамга, тэмдэг)	(Тамга, тэмдэг)
(Гарын үсэг)	(Гарын үсэг)
(Албан тушаал)	(Албан тушаал)

[Тендер шалгаруулалт/гэрээний нэр] гэрээ.

Дугаар № [Тендер шалгаруулалт/гэрээний дугаар]

..... хот/аймаг

Нэг талаас [захиалагчийн нэр] (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас [гүйцэтгэгчийн хот, улс, гүйцэтгэгчийн нэр] (цаашид “гүйцэтгэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож _____ оны _____ сарын _____ -ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний хууль, Барилгын тухай хууль болон бусад хууль тогтоомжийн дагуу инженерийн хийцтэй барилга байгууламж барих, засварын ажил гүйцэтгэх, тоног төхөөрөмж сууринуулахтай холбогдон захиалагч, гүйцэтгэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.

2. Захиалагч нь [гэрээний нэр, дугаар]-г (цаашид “ажил” гэх) [гэрээний үнийг тоогоор болон үсгээр] (цаашид “гэрээний үнэ” гэх) гүйцэтгэхээр ирүүлсэн гүйцэтгэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ буюу ажлын нийт төсөвт өртөг нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.

3. Гэрээний нийт дүн: _____ төгрөг. Үүнээс: /Аль тохирохыг нь бөглөнө, бусдыг нь устгана/

Улсын төсвөөс: 20.... онд: _____ төгрөг; 20.... онд: _____ төгрөг;

Орон нутгийн төсвөөс: 20.... онд: _____ төгрөг; 20.... онд: _____ төгрөг;

Өөрийн хөрөнгө: 20.... онд: _____ төгрөг; 20.... онд: _____ төгрөг.

4. Гүйцэтгэгч нь _____ байршилтай _____ хүчин чадал бүхий _____ ам.метр талбай / _____ шоо метр эзлэхүүн/-тай, _____ суурь, _____ хана, _____ хучилттай, _____ давхар _____ барилга угсралт /барилгын засвар, тоног төхөөрөмж сууринуулах/-ын ажлыг _____ инженерийн шугам сүлжээ /дулаан, цахилгаан, цэвэр, бохир усан хангамж/, _____ туслах барилга /бусад ажил/-ын хамт _____ оны _____ дугаар сарын _____ -ны өдөр эхэлж, _____ оны _____ дугаар сарын _____ -ны өдөр ашиглалтад оруулна.

5. Дор дурдсан баримт бичиг нь гэрээний салшгүй хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:

- 5.1. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;
- 5.2. Бусад шаардлагатай баримт бичиг ;
- 5.3. Үнийн санал
- 5.4. Гэрээний тусгай нөхцөл;

- 5.5. Гэрээний ерөнхий нөхцөл;
- 5.6. Техникийн тодорхойлолт;
- 5.7. Зураг;
- 5.8. Гүйцтгэгчийн ирүүлсэн үе шатны ажлын хуваарь :
- 5.9. Санхүүжилтийн хуваарь;
- 5.10. Ажил гүйцэтгэх хуваарь.

Гэрээ нь энд дурдсан ажлыг гүйцэтгэх талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний бичиг баримтууд хоорондоо зөрчилдвэл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

6. Захиалагч, гүйцэтгэгч нь гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлд заасан эрх, үүрэг хүлээнэ.

7. Гүйцэтгэгч нь гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан ажлыг гүйцэтгэж, зөрчил, гологдол арилгах үүрэг хүлээнэ.

8. Захиалагч нь гэрээний дагуу гүйцэтгэгчийн хийх ажил болон зөрчил, гологдол арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний төлбөрийг гүйцэтгэгчид төлөх үүрэг, хүлээнэ.

9. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр болон утсан холбоогоор харилцана.

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]
[Гарын үсэг]_____

ТАМГА

[Захиалагчийн хаяг]
[Утас/факсын дугаар]
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]

ГҮЙЦЭТГЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]
[Гарын үсэг]_____

ТАМГА

[Захиалагчийн хаяг]
[Утас/факсын дугаар]
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]